


Манай орны 12 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар -21°C (-5.8°F)-аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар -15°C -аас -9°C (5°F -аас 15.8°F), бусад нутгаар -15°C -аас -24°C (5°F -аас -11.2°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 12 дугаар сард хур тунадас бага унадаг бөгөөд ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 1 хувьтай тэнцдэг. Олон жилийн дунджаар (1991-2020 оны дунджаар) сардаа томоохон гол, нуурын сав газар болон Ховдын зүүн өмнөд хэсгээр 4 мм-ээс их, бусад нутгаар 0.5-3.8 мм тунадас унадаг.



Зураг 1. 1991-2020 оны 12 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны оронзайн тархалт

2025 оны 12 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -0.3°C -аар хүйтэн, ОЖД-аас 1.1°C -аар дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 31 дэх дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 11.6% нь дунджаас -1.1°C -аас -3.0°C -аар хүйтэн, 32.6% нь дунджийн орчим, 55.8% нь дунджаас 1.1°C –аас 5.4°C -аар дулаан байжээ.


Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 1.6 мм тунадас орсон нь өмнөх жилээс 55.8%-иар, ОЖД-аас 47.3%-иар тус тус бага хур тунадас орсон ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 19 дэх бага тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 74.4% нь дунджаас бага, 7.0% нь дунджийн орчим, 18.6% нь ахиу тунадас унасан байна.



Зураг 2. 2025 оны 12 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт


Нийт нутгаар болон дөрвөн бүсээр хуваан дунджилсан арван хоёрдугаар сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзвэл (Зураг 3), нийт нутгаар сарын ихэнх хугацаанд олон жилийн дунджаас (ОЖД) $0.1-8.6^{\circ}\text{C}$ -аар дулаан байжээ. Харин 1 болон 2 дугаар арав хоногийн эхэн үе болон 3 дугаар 10 хоногийн эхэн ба сүүлчээр ихэнх нутгаар хүйтрэлт ажиглагдаж, агаарын температур ОЖД-аас $0.2-9.9^{\circ}\text{C}$ -аар хүйтэрсэн байна.

Хур тунадасны хувьд хоёрдугаар арав хоногоос бусад хугацаанд нийт нутгаар харьцангуй бага хур тунадастай, зарим газарт бараг хур тунадасгүй байжээ.




Зураг3. Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

12 дугаар сард -30°C -аас хүйтэн өдрийн тоо Завханы Отгон, Баянхонгорын Байдраг, Хөвсгөлийн Ренчинхлүмбэ, Цагаан-Үүр орчмоор 20 өдрөөс их, Увсын Тэс, Завханы Баянтэс, Сэлэнгийн Ерөө, Төв аймгийн Алтанбулаг, Улаанбаатарын Багануур, Буянт-Ухаа орчмоор 15-19 хоног, бусад нутгаар 1-10 хоног ажиглагджээ. Говийн болон баруун, зүүн бүсийн ихэнх нутгаар огт ажиглагдаагүй.



Зураг 4. -30°C -аас хүйтэн өдрийн тооны оронзайн тархалт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Ховд аймгийн Чандмань суманд 5.5°C , үнэмлэхүй бага утга Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ суманд -40.7°C хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй Өмнөговь аймгийн Гурвантэс суманд 14°C , үнэмлэхүй бага утга Улаанбаатарын Тэрэлж орчимд -45°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Завхан аймгийн Завханмандал суманд 11-ний өдөр 5.6 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 960.4гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 760гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Говь-Алтай аймгийн Бугат суманд 32м/с хүрчээ.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд